



## "УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР" ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 02 дугаар  
сарын 19-ний өдөр

Дугаар: 21/04

Улаанбаатар  
хот

Ногдол ашиг хуваарилах эсэх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйл, 80 дугаар зүйлийн 80.4 дэх хэсэг, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн саналын хуудсын үр дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компани 2020 оны 06 дугаар сард "Улсын их дэлгүүр"-т гал гарсан нөхцөл байдал болон Ковид-19 цар тахлын улмаас тайлант жил болон өмнөх онуудад бий болсон хуримтлагдсан алдагдлаа нөхөж чадаагүй, үйл ажиллагаа нь доголдсон, Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.8 дахь хэсэг, 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсэгт заасан ногдол ашиг хуваарилах шаардлагыг хангаж чадахгүй байгаа зэргийг тус тус харгалзан 2020 оны тайлант жилийн үйл ажиллагааны орлогоос хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсүгэй.
2. Компанийн Гүйцэтгэх захирлын 2020 оны ажлын тайлан, ногдол ашиг хуваарилахгүй байх тухай ТУЗ-ийн шийдвэрийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оруулан танилцуулахаар тогтоосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



Ө.ҮНЭНБҮРЭН

**“Улсын их дэлгүүр” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн  
2021.02.19-ний өдрийн санал хураалтын дүнг нэгтгэсэн тэмдэглэл**


Огноо: 2021-02-19

д/д	Санал хураалтаар шийдвэрлэсэн асуудал	Санал хураалтын ирц	Санал өгсөн ТУЗ-ийн гишүүн	ТУЗ-ийн гишүүний санал
1	Компани 2020 оны 06 дугаар сард “Улсын их дэлгүүр”-т гал гарсан нөхцөл байдал болон Ковид-19 цар тахлын улмаас тайлант жил болон өмнөх онуудад бий болсон хуримтлагдсан алдагдлаа нөхөж чадаагүй, үйл ажиллагаа нь доголдсон, Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.8 дахь хэсэг, 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсэгт заасан ногдол ашиг хуваарилах шаардлагыг хангаж чадахгүй байгаа зэргийг тус тус харгалзан 2020 оны тайлант жилийн үйл ажиллагааны орлогоос хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэх.	89%	Ш.Баярсайхан	Зөвшөөрсөн
			Ө.Үнэнбүрэн	Зөвшөөрсөн
			Я.Наваан	Зөвшөөрсөн
			Б.Бямбаноров	Зөвшөөрсөн
			А.Норсмаа	Зөвшөөрсөн
			С.Хосбаяр	Зөвшөөрсөн
			Д.Дашцэдэн	Зөвшөөрсөн
			Н.Батцацрал	Зөвшөөрсөн

Санал хураалтын дүн: ТУЗ-ийн нийт 9 гишүүнээс 8 гишүүн санал өгсөн ба санал хураалтаар шийдвэрлэх асуудлыг санал өгсөн гишүүдийн 100%-ийн саналаар зөвшөөрсөн.

Санал хураалтын дүнг нэгтгэсэн:

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга:

  
 М.Өлзийбат